



**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Монгол Ардын Хувьсгалт Намыг улсын
бүртгэлээс хасч, нийтэд мэдээлэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Тунгалаг, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, С.Батдэлгэр, М.Батсуурь, Б.Батцэрэн, Г.Банзрагч, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, Д.Мөнхтуяа, Х.Сонинбаяр, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Г.Цагаанцоож, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, “Монгол Ардын Хувьсгалт Намын үйл ажиллагааг зогсоож буйг хууль ёсны дагуу бүртгэн, МАХН-ыг улсын бүртгэлээс хасч, энэ тухай нийтэд мэдээлэх тухай” өргөдлийг шүүгч М.Батсуурийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

МАХН-ын дарга Авишиг-Орших овогтой Намбарын Энхбаяр нь 2021.05.21-ний өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн өргөдөлдөө: “МАХН-ын Ээлжит бус Их чуулган 2021.05.16-ны өдөр хуралдаж, намын гишүүдийн дунд явуулсан хэлэлцүүлгийн дүнг үндэслэн “МАХН-ын үйл ажиллагааг зогсоож МАН-тай нэгдэх тухай” Ээлжит бус Их чуулганы 11 дүгээр тогтоол гарсан. Иймд, МАХН-ын үйл ажиллагааг зогсоох тухай өргөдлийг хүлээн авч, хууль ёсны дагуу улсын бүртгэлээс хасч өгнө үү” гэжээ.

Мөн МАХН-ын даргын 2021.05.20-ны өдрийн “МАХН-ын үйл ажиллагааг зогсоосныг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай” 1/14 дүгээр албан бичгээр ирүүлсэн хүсэлтдээ: “Монгол Ардын Хувьсгалт Намын Ээлжит бус Их чуулган 2021.05.16-ны өдөр хуралдаж, тус Ээлжит бус Их чуулганы 11 дүгээр тогтоолоор МАХН-ын үйл ажиллагааг зогсоож, МАН-тай нэгдэх тухай шийдвэрийг гаргаад байна. Ийнхүү шийдвэрлэхдээ МАХН-ын дүрмийн 10 дугаар зүйлийн 10.5.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.4 дэх заалт, Улсын төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.5, 15.7 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2021.03.29-ний өдрөөс 6 хоногийн хугацаанд МАХН-ын гишүүдийн дунд явуулсан хэлэлцүүлгийн дүн, МАХН-ын Бага чуулганы 11, 12 дугаар хуралдааны шийдвэрүүд, МАХН-ын Гүйцэтгэх товчооны шийдвэрүүдийг тус тус удирдлага болгож шийдвэрлэсэн. Иймд, МАХН үйл ажиллагаагаа зогсоож

буйг хууль ёсны дагуу бүртгэн, МАХН-ыг улсын бүртгэлээс хасч, энэ тухай нийтэд мэдээлэхийг хүсье” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

МАХН-ын намын дарга Н.Энхбаярын “Монгол Ардын Хувьсгалт Намын үйл ажиллагааг зогсоож буйг хууль ёсны дагуу бүртгэн, МАХН-ыг улсын бүртгэлээс хасч, энэ тухай нийтэд мэдээлэх тухай” өргөдөл, түүнд холбогдох баримтууд нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021.04.12-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.8-д заасан бүрдлийг хангасан, уг журмын хавсралт №4, 4А¹-д заасны дагуу холбогдох баримтыг бүрдүүлэн ирүүлсэн байх тул өргөдөлд дурдсан хүсэлтийг хангаж шийдвэрлэлээ.

Улс төрийн намын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Намын удирдах дээд байгууллага нь намын Их Хурал байна” гээд 13.2.3-т “намыг өөрчлөн байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, намын нэрийг өөрчлөх” асуудлыг зөвхөн намын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэхээр зохицуулжээ.

МАХН-ын дүрмийн Есдүгээр зүйлийн 9.1-д “МАХН-ын удирдах дээд байгууллага нь намын Их чуулган, төлөөллийн төв байгууллага нь намын Бага чуулган байна” гэж заасан бөгөөд Аравдугаар зүйлийн 10.2-т “Намын ээлжит Их чуулганыг хуралдуулах товыг Бага чуулганаас тогтооно”, 10.3-т “Намын Их чуулганы төлөөлөгчдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг намын Бага чуулганаас тогтооно”, 10.5-д “Намын Их чуулган намын бодлогын ямар ч асуудлыг авч хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ. Үүнд:” гээд 10.5.3-т “Намын бүх гишүүдийн дунд явуулсан чөлөөт хэлэлцүүлгийн дүнг үндэслэн намын нэр, үзэл баримтлалыг өөрчлөх, намыг өөрчлөн байгуулах” гэж МАХН-ын Их чуулганы бүрэн эрхийг тодорхойлсон байна.

Мөн дүрмийн Арваннэгдүгээр зүйлийн 11.1-д “Намын Их чуулганд сонгогдсон нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцож байгаа бол намын Их чуулганыг хүчинтэйд тооцно”, 11.3-т “Намын Их чуулганы шийдвэр нь тогтоол байна”; Арванхоёрдугаар зүйлийн 12.3-т “Намын ээлжит бус Их чуулганыг энэ дүрмийн 10.2, 10.3-т зааснаар товлон хуралдуулна” гэжээ.

Өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаас үзэхэд, МАХН-ын 2021.05.16-ны өдрийн Ээлжит бус Их чуулганы хуралдаан нь тус намын дүрэмд заасан журмын дагуу явагдсан болох нь тогтоогдож байна.

¹ Өргөдөл, намын бүтэн болон товчилсон нэр, намын регистрийн дугаар (намын гэрчилгээний эх хувь), үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр, тэмдэглэл, түүнтэй холбоотой баримт, дуусгалтын тайлан, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, татвар төлөгчийн хасалтын карт, өртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын лавлагаа, үйл ажиллагааг зогсоох тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар, өргөдөл гаргагч этгээдийн хувийн мэдээлэл.

Тодруулбал, МАХН-ын Бага чуулганы хуралдааны 2021.05.03-ны өдрийн 10 дугаар тогтоолын 1 дэх заалтаар тус намын Ээлжит бус Их чуулганы 2021.05.16-ны өдрийн 10 цагт цахимаар хуралдуулахаар товлож, 2 дахь заалтаар тус чуулганы төлөөлөгчдийн тоог нэгдүгээр хавсралтаар баталсан бол 3 дахь заалтаар Ээлжит бус Их чуулганы төлөөлөгч сонгох журмыг хоёрдугаар хавсралтаар баталсан; мөн МАХН-ын Бага чуулганы хуралдааны 2021.05.15-ны өдрийн “Ээлжит бус Их чуулганы төлөөлөгчөөр сонгогдсон гишүүдийн нэрсийг баталгаажуулах тухай” 09 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар МАХН-ын Ээлжит бус Их чуулганы төлөөлөгчөөр Түмтийн зөвлөлийн хурлаас сонгогдсон гишүүдийн нэрсийг баталгаажуулж, 723 төлөөлөгч оролцохоор, 2 дахь заалтаар Ээлжит бус Их чуулганд квотоор оролцох гишүүдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар баталгаажуулж, квотоор оролцох төлөөлөгчдийн тоог 60 хүртэл тогтоосноос 57 төлөөлөгч оролцохоор шийдвэрлэжээ.

МАХН-ын Ээлжит бус Их чуулганы 2021.05.16-ны өдрийн хуралдаанд нийт 779 төлөөлөгч оролцох ёстойгоос 757 төлөөлөгч оролцож, 22 төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцоогүй буюу 97.2 хувийн ирцтэй хуралдаж, МАХН нь МАН-тай нэгдэн нийлэх гэрээ, гэрээний хавсралтыг сайшаан баталсан, 2021.05.16-ны өдрөөр МАХН-ын үйл ажиллагааг зогсоож байгаа талаар хуралдаанд оролцсон нийт гишүүд буюу 757 төлөөлөгчийн 100 хувийн саналаар дэмжсэнийг баталж, 11 дүгээр тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолд “Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүдийн дунд явуулсан чөлөөт хэлэлцүүлгийн дүн, МАХН-ын дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт, Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.5, 15.7 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэл болгон 1 дэх заалтаар МАХН-ын үйл ажиллагааг 2021.05.16-ны өдрөөр тасалбар болгон зогсоож МАН-тай нэгдэх, 2 дахь заалтаар МАХН-ын үйл ажиллагааг зогсоож, МАН-тай нэгдэх тухай тогтоол болон холбогдох бусад бичиг баримтыг хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад хүргүүлэх, 3 дахь заалтаар МАХН үйл ажиллагаагаа зогсоож, МАН-тай нэгдсэнийг олон нийтэд мэдээлэх”-ээр тус тус шийдвэрлэжээ.

Улс төрийн намын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Нам үйл ажиллагаагаа намын эрх барих дээд байгууллагын шийдвэрээр зогсоох бөгөөд ажлын 5 өдөрт багтаан Улсын дээд шүүхэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ. Улсын дээд шүүх ажлын 5 өдөрт багтаан уг намыг улсын бүртгэлээс хасч, нийтэд мэдээлнэ. Энэ тохиолдолд намын хөрөнгийг түүний дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасан; МАХН-ын даргаас 2021.05.21-ний өдөр тус шүүхэд хандан гаргасан өргөдөл, түүнд хавсаргасан баримтын бүрдэл нь хуулийн энэхүү заалт болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Улсын Дээд шүүхийн Улс төрийн намын бүртгэл хөтлөх журмын хавсралт №4, 4А-д заасан шаардлагыг хангасан байх тул хүсэлтийг хангаж, МАХН-ыг улсын бүртгэлээс хасч, нийтэд мэдээлэх нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас шийдвэрлэлээ.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 25 дугаар зүйлийн 25.8.8 дахь хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасныг баримтлан Монгол Ардын Хувьсгалт Намыг улсын бүртгэлээс хасч, нийтэд мэдээлсүгэй.

2. Хүсэлт гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдөр төлсөн 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ДАРГАЛАГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

М.БАТСУУРЬ